



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 298

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 6.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Завхан аймгийн Статистикийн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 42,900,000.00 (дөчин хоёр сая есөн зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 36,345,833.15 (гучин зургаан сая гурван зуун дөчин таван мянга найман зуун гучин гурван төгрөг арван таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Хил хамгаалах ерөнхий газарт балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга Б.Лхагва, Завхан аймаг дахь Статистикийн хэлтсийн дарга А.Өнөрбат, Хилийн цэргийн 0165 дугаар ангийн захирагч Р.Эрдэнэтогтох нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгө хүлээн авсны дараа үлдэх өртөггүй хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналаа ирүүлж шийдвэрлүүлэх,

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.4 Автотээврийн хэрэгслийг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

133001436
14-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2025 оны 06 дугаар сарын 28 нын өдрийн
 дугаар тогтоолын хавсралт

ЗАВХАН АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ
 ХИЛИЙН ЦЭРГИЙН 0165 ДУГААР АНГИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр, төрөл	Үйлдвэрлэгд- сэн, ашиглалтад орсон огноо	Арлын дугаар	Улсын дугаар	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	ЛАДА 2131 суудлын автомашин	2019/2019	ХТА213100L0211245	8109 ЗАВ	42,900,000.00	36,345,833.15	6,554,166.85
НИЙТ ДҮН					42,900,000.00	36,345,833.15	6,554,166.85
					(дөчин хоёр сая есөн зуун мянга)	(гучин зургаан сая гурван зуун дөчин таван мянга найман зуун гучин гурван төгрөг арван таван мөнгө)	(зургаан сая таван зуун тавин дөрвөн мянга нэг зуун жаран зургаан төгрөг наян таван мөнгө)